

ГАДААД ХЭЛНИЙ ДАМЖААНД СУРАЛЦУУЛАХ ЖУРАМ

Нэг: Нийтлэг үндэслэл

1.1. Зэвсэгт хүчний Гадаад хэлний сургалтын төв, Зэвсэгт хүчний 084, 150, 311, 330 дугаар ангиудын гадаад хэлний дамжаанд суралцагчдыг сонгон шалгаруулах, суралцуулахтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Энэхүү журмын зорилго нь Зэвсэгт хүчинд идэвхи зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж байгаа офицер, ахлагч нарыг гадаадын цэргийн академи, их, дээд сургуулиудад сургах, энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах бие бүрэлдэхүүнд гадаад хэлний мэдлэг олгоход оршино.

1.3. Суралцагсдыг сонгон шалгаруулах, суралцуулах эрх зүйн үндэс нь “Зэвсэгт хүчний тухай”, “Төрийн албаны тухай”, “Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай” зэрэг Монгол Улсын хуулиуд, “Офицерын алба хаах журам”, “Ахлагчийн алба хаах журам” болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан энэхүү журам бусад эрх зүйн баримт бичгүүд байна.

1.4. Зэвсэгт хүчний офицер, ахлагч нар Зэвсэгт хүчний Гадаад хэлний сургалтын төв, Зэвсэгт хүчний 084, 150, 311, 330 дугаар ангиудын англи хэлний дамжаанд үнэ төлбөргүй суралцана.

1.5. Энэхүү журмыг Зэвсэгт хүчний Жанжин штабын /цаашид ЗХЖШ гэх/ <http://www.gsmaf.gov.mn> цахим хаяг, Зэвсэгт хүчний хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд байршуулан, бүртгүүлэхийг хүсэгчдийг танилцах нөхцлөөр хангана.

1.6. Журмын хэрэгжилт, суралцагчдын сурах үйл ажиллагаанд ЗХЖШ-ын зохион байгуулалтын нэгж, командлал, анги байгууллагаас хөндлөнгийн хяналт тавих нөхцлийг бүрдүүлнэ.

Хоёр: Дамжаанд элсэгчдэд тавигдах шаардлага

2.1. Дамжаанд суралцагч нь Цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллагаас тогтоосон боловсрол, мэргэжил, ур чадвар, эрүүл мэнд, сэтгэл зүйн шалгуур үзүүлэлтийг хангасан, зан чанар, ёс суртахууны зөв төлөвшилтэй, төрийн албан хаагчийн болон офицер, ахлагчийн ёс зүйн шаардлагыг хангасан байна.

2.1.1. Элсэхээр бүртгүүлэгч нь өөрийн хүсэл сонирголоороо сонголтоо хийсэн, бүрэн дунд түүнээс дээш боловсролтой,

2.1.2. Зэвсэгт хүчинд 3 /гурав/-аас доошгүй жил үр бүтээлтэй ажиллаж байгаа,

2.1.3. Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн,

2.1.4. Гадаад хэл сурах чин хүсэл эрмэлзэл, идэвхи сонирхолтой,

2.1.5. Ёс суртахууны зөв төлөвшилтэй, сахилга, ёс зүйн зөрчилгүй байна.

Гурав: Дамжаанд суралцагсдыг сонгон шалгаруулах

3.1. Гадаад хэлний сургалтын хөтөлбөрийг танилцуулах, элсэлтийн талаарх мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх үйл ажиллагааг Хүний нөөцийн хэлтэс, Гадаад хэлний сургалтын төв хамтран зохион байгуулна.

3.2. Хүний нөөцийн хэлтсээс Гадаад хэлний дамжаа эхлэхтэй холбогдуулан ЗХЖШ-ын зохион байгуулалтын нэгж, командлалуудад албан бичгээр 1 /нэг/ сарын өмнө хүргүүлнэ.

3.3. ЗХЖШ-ын зохион байгуулалтын нэгж, командлалууд харьяа анги байгууллагуудаас шаардлага хангасан офицер, ахлагч нарыг сонгон, суралцуулах албан тушаалтнуудын нэр, саналаа холбогдох материалын хамт Хүний нөөцийн хэлтэст заасан хугацаанд ирүүлнэ.

3.4. Дамжаанд суралцагч дараах материалыг бүрдүүлнэ.

- ЗХЖШ-ын зохион байгуулалтын нэгж, командлалын зөвшөөрөл, анги байгууллагын даргын санал /албан бичгээр/,

- Боловсролын гэрчилгээний хуулбар, баримт бичиг,

- Ажил байдлын тодорхойлолт,

- Дамжаанд суралцах өргөдөл,

- 3x4 хэмжээний цээж зураг 2 хувь, /албаны дүрэмт хувцастай/

3.5. Хүний нөөцийн хэлтэс ЗХЖШ-ын зохион байгуулалтын нэгж, командлалуудаас ирүүлсэн саналыг нягтлан, сонгон шалгаруулалтыг /ерөнхий мэдлэг, сэтгэн бодох ой тогтоолт/ тест, ярилцлага хэлбэрээр зохион байгуулна.

3.6. Сонгон шалгаруулалтын дүнг ЗХЖШ-ын удирдлагад танилцуулж, тэнцсэн офицер, ахлагч нарыг Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын тушаалаар Гадаад хэлний дамжаанд суралцуулна.

3.7. Зэвсэгт хүчний анги байгууллагын захирагч дарга сонгон шалгаруулалтад тэнцсэн офицер, ахлагчийг дамжаанд суралцуулах нөхцөлөөр хангана.

3.8. Гадаад хэлний дамжаанд элссэн суралцагч нэг бүртэй суралцах хугацааны гэрээг Хүний нөөцийн хэлтэс байгуулж, хяналт тавьж ажиллана.

3.9. ЗХЖШ-ын зохион байгуулалтын нэгж, командлал, анги байгууллагын захирагч, дарга нар дамжаанд суралцагчийг сонгохдоо хамт олонд ил тод, нээлттэй, шударгаар шийдвэрлэх үүрэгтэй.

Дөрөв. Суралцагчийн эрх, үүрэг, хариуцлага

4.1. Суралцагчийн эрх:

4.1.1. Суралцагч суралцаж буй хугацаандаа цалин хөлсөө авах,

4.1.2. Сургалтын анги танхим, техник хэрэгсэл, ном, сургалтын материалаар хангагдах,

4.1.3. Сургалт, багшийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар гомдол, санал гаргах,

4.2. Суралцагчийн үүрэг:

4.2.1. ЗХЖШ-ын Хүний нөөцийн хэлтэстэй байгуулсан гэрээний заалтуудыг хэлбэрэлтгүй хэрэгжүүлэх,

4.2.2. Хичээл, сургалтанд бүрэн хамрагдах, албан үүргийн дагуу багш нарын тавьсан шаардлагыг биелүүлэх,

4.2.3. Хичээлд идэвхи санаачилгатай оролцох, гэрийн даалгавраа цаг тухайд нь хийх, бие дааж суралцах арга барилыг эзэмших, байгууллагын дотоод журмыг сахих,;

4.2.4. Сургалтын ном, материалыг гамтай эдэлж, хэрэглэх,

4.2.5. Суралцах хугацаандаа өвчний болон ар гэрийн гачигдлаар чөлөө авах тохиолдолд орон нутаг руугаа явах, ирэх унааны болон бусад зардлыг өөрөө хариуцах,

4.2.6. Хөдөө, орон нутгаас ирсэн суралцагч замын зардал, байр, хоол, унааны зардлаа өөрөө хариуцна.

4.2.7. Дамжаанд суралцагч сурч мэдсэнээ баяжуулан, бие даан суралцах замаар гадаад хэлний мэдлэг ур чадвараа байнга дээшлүүлж, батжуулах үүрэгтэй.

4.3. Хариуцлага

4.3.1. Дамжаанаас сурлага, сахилгаар болон өөрийн буруутай шалтгаанаар хасагдсан, хөөгдсөн тохиолдолд сургалтын зардлыг нөхөн төлнө.

4.3.2. Суралцагч сургалтын техник хэрэгсэл, ном, гарын авлагыг гэмтээх, үрэгдүүлвэл хохиролгүй болгоно.

4.3.3. Даалгавар хийгээгүй тохиолдол бүрийг нэг цагийн хичээл тасалсанд тооцно.

4.3.4. Хичээл тасалвал, ажил тасалсанд тооцно.

4.3.5. Сургалтын явцад хүндэтгэх шалтгаангүйгээр 18 /арван найм/ цагийн хичээл тасалвал дамжаанаас хасна.

4.3.6. Дамжаанаас сурлага, сахилгаар болон өөрийн буруутай шалтгаанаар хасагдсан, хөөгдсөн офицер, ахлагчийг 3 /гурав/ жилийн хугацаанд сургалт, дамжаанд хамруулахгүй.

4.3.7. Дамжаа төгсөөд 5 /тав/ жилийн дотор өөрийн хүсэлтээр болон сахилга хариуцлагаар Зэвсэгт хүчнээс халагдвал, ажилласан 1 жилийг 20 хувиар бодож, сургалтын зардлыг төлүүлнэ.

4.3.8. Гадаад хэлний дамжаанд суралцагсдын сурлага, сахилгын дүнг сар бүр гаргаж, ЗХЖШ-ын удирдлагад танилцуулж, холбогдох арга хэмжээ авна.

4.3.9. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэлгүй, сурлага, сахилгаар дамжаанаас хасагдсан офицер, ахлагчийн суралцах хугацааны гэрээг цуцалж, Монгол Улсын хууль тогтоомж, Цэргийн дүрэм болон энэхүү журмыг үндэслэн сахилгын шийтгэл ногдуулна.

Тав. Дамжааны сургалт

5.1. Гадаад хэлний дамжаа нь анхан, бэлтгэл дунд, дунд шатны сургалтаас бүрдэх бөгөөд дамжаа тус бүр 3 /гурав/ сар үргэлжилнэ. Танхимийн сургалт долоо хоногийн ажлын 5 өдөр, өдөрт 6 цагаар хичээллэх ба суралцагч нь багшийн удирдлага зааврын дагуу 2 цагийн бие даалтыг танхимдаа хийнэ.

5.2. Ном, хичээлийн сэдэв бүрийн төгсгөлд шалгалтыг тестийн хэлбэрээр авна, Гадаад хэлний түвшин тогтоох тест болон ур чадварын цогцолбор шалгалтыг дамжааны төгсгөлд тус тус авна.

5.3. Суралцагч нь сургалтын явцын ба номын шалгалтуудад 75-аас дээш оноо авсан тохиолдолд “Хангалттай” түүнээс доош оноо авсан тохиолдолд “Хангалтгүй” буюу шаардлага хангаагүйд тооцно.

5.4. Сургалтын явцын ба номын шалгалтад 3 удаа 75-аас доош оноо авсан тохиолдолд суралцагчийг дамжаанаас хасах үндэслэл болно. Мөн хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шалгалтанд ороогүй суралцагчаас нөхөн шалгалтыг авахгүй бөгөөд тухайн шалгалтанд “0” оноо авсанд тооцно.

5.5. Суралцагчийг дараагийн шатны сургалтад үргэлжлүүлэн суралцуулах асуудлыг суралцсан байдал, идэвхи чармайлт, албан ажлын шаардлагыг харгалзан Зэвсэгт хүчний Гадаад хэлний сургалтын төвийн санал, Хүний нөөцийн хэлтсийн дүгнэлтийг ЗХЖШ-ын удирдлагад танилцуулж, шийдвэрлэнэ.

5.6. Суралцагчдад хүндэтгэн үзэх шалтгаанаар хичээлийн нэг өдрийн чөлөөг Зэвсэгт хүчний Гадаад хэлний сургалтын төвийн дарга, түүнээс дээш өдрийн чөлөөг тус Сургалтын төвийн даргаар уламжлан Хүний нөөцийн хэлтэст өргөдөл гаргаж асуудлыг шийдвэрлүүлнэ.

5.7. Гадаад хэлний дамжаанд суралцуулахаар ЗХЖШ-ын даргын тушаалаар ажлаас түр чөлөөлөгдсөн суралцагчдыг сургалтын явцад анги, байгууллагаас дуудаж, сургалтын үйл ажиллагаанд саад учруулахыг хориглоно.

5.8. Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын даргын санал хүсэлтээр албан хаагчдыг нь дамжаанд хамруулж болно. Нэг ангид дээрх байгууллагуудын албан хаагч 2-оос илүүгүй байна.

5.9. Сургалтын зардлыг Санхүүгийн хэлтэс, Гадаад хэлний сургалтын төв хамтран жил бүр тогтооно.

Зургаа. Дамжаанд суралцагсдын судалгаа, тоо бүртгэл

6.1. Гадаад хэлний дамжаанд суралцагсдын судалгаа, тоо бүртгэлийг Хүний нөөцийн хэлтсийн мэргэжлийн сургалт хариуцсан мэргэжилтэн хариуцаж, Зэвсэгт хүчний хүний нөөцийн мэдээллийн санд хадгална.

6.2. ЗХЖШ-ын Хүний нөөцийн хэлтсийн тоо бүртгэл хариуцсан ажилтан болон анги байгууллагын хүний нөөцийн мэргэжилтнүүд гадаад хэлний дамжаанд суралцсан офицер, ахлагч нарын алба хаах бүртгэл картад гадаад хэлний мэдлэгийн түвшин, сурлагын дүнг тухай бүр тэмдэглэж, хувийн хэрэгт нь баяжилт хийнэ.

6.3. Гадаад хэлний дамжаанд амжилттай суралцсан цэргийн албан хаагчдыг судалгаанд авч, гадаадын цэргийн академи, их, дээд сургууль, дамжаа, энхийг дэмжих ажиллагаанд оролцуулахаар сонгон шалгаруулалтад хамруулна.

ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТЭС